МЭДЭЭ · 2022 оны 3-р сарын 25

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ГАРСАН ТӨЛБӨРИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАНА



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас харьяа Цагдаагийн газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албадуудтай хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж, эрүүгийн хэрэгт эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөр гаргуулсан тохиолдолд иргэний нэхэмжлэл гарган буруутай этгээдээс хохирлыг нөхөн төлүүлэхэд мөрдөгч, прокуророос анхаарах асуудлын талаар хэлэлцсэн байна.

Зөвлөгөөнд Чингэлтэй дүүргийн прокурорын газрын шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан ахлах прокурор Б.Байгалмааг урьж, тус дүүргийн прокурорын газраас дээрх чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлын талаар мэдээлэл авч, туршлагыг нэвтрүүлж ажиллахаар шийдвэрлэжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2409